



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А1605

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн Хөхморьт сумын нэгдсэн халаалтын зуух, төвлөрсөн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Б.Лхагва-Очир	(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
	Д.Баярчулуун	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер)
	Д.Наранбадрах	(Хөхморьт сумын Засаг дарга)
Б.Батбаатар	(Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын дарга)	

2.

Ш.Соронзонболд (Буман хаус ХХК-ийн захирал)
(гүйцэтгэгч)


Ж.Бат-Эрдэнэ ("Дулаан проект" ХХК-ийн захирал)
(туслан гүйцэтгэгч)

Л.Энхсайхан ("ДНТ" ХХК-ийн захирал) (зохиогч)

Нарийн бичгийн дарга: Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын барилгын
асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Дулаан проект" ХХК-ийн захирал (Ж.Бат-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ